

Таваарын зах зээлийн долоо хоногийн тойм

Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв

2022.01.10

Нүүрс
Төмрийн хүдэр
Зэс



НҮҮРСНИЙ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2022 оны 01-р сарын 10

Долоо хоногийн онцлох үйл явдал

Өнгөрсөн долоо хоногт Индонез улс БНХАУ-руу экспортолж байгаа нүүрсний экспортоо зогсоолоо. Индонез улсын эрчим хүчний яамны удирдлагуудын нэг Ridwan Jamaludin-ийн хэлж байгаагаар тус улсад эрчим хүчний хомсдол үүсэх магадлал маш өндөр байгаа бөгөөд хэрэв нүүрсний экспортоо зогсоогүй бол эрчим хүчний 20 цахилгаан станц зогсож 10,850 мегават эрчим хүч алдагдах төлөвтэй байгаа бөгөөд зоримог арга хэмжээ авахгүй бол тог цахилгаангүй болох төлөвтэй байгааг мэдэгдсэн.

Bank Mandiri-ийн шинжээч Ahmad Zuhdi Dwi Kusuma-ийн хэлж байгаагаар Индонезийн нүүрсний экспортын хориг нь дэлхий даяар нүүрсний ханшийг өсгөх томоохон хөшүүрэг болох төлөвтэй байгаа бөгөөд Индонезийн нүүрс худалдан авагчид ОХУ, Австрали, Монгол Улс-руу шилжих төлөвтэй байгааг мэдэгдсэн байна. Шинжээчдийн үзэж байгаагаар Индонези Улсын эдийн засгийн өсөлт нь төсөөлж байснаас хурдан байсан бөгөөд энэ нь эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэхэд хүргэсэн байна.

Published on Investing.com, 10/Jan/2022 - 3:42:34 GMT. Powered by TradingView
ZCE Thermal Coal, China, ZCE:CZCct1.D



БНХАУ-д нүүрс экспортлогч голлох улс экспортоо хязгаарласан хэдий ч энэ нь ханшид төдийлөн нөлөөлж чадахгүй байна. 2 сарын 1 өдөр БНХАУ-ын цагаан сарын баярын өдрүүд эхлэх бөгөөд 7 хоногийн хугацаатай үргэлжлэх юм. Баярын өдрүүдэд эрчим хүчний нийлүүлэлтийг тогтвортой байлгахын тулд БНХАУ-ын засгийн газраас сүүлийн сард нүүрсний нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч хэргэжүүлж байсан бөгөөд 1 сарын 1 өдрийн байдлаар БНХАУ-ын далайн эргийн хот мужуудын нүүрсний нөөц 33 сая тонн буюу өмнөх оны мөн үеэс 57 хувиар өндөр байгаа юм байна.

Мөн 2 сарын 4 өдөр Өвлийн олимп эхлэх бөгөөд голлох агаарын бохирдол үүсгэхүйц голлох үйлдвэрүүдийн эрчим хүчний хэрэглээг хязгаарлаж үйлдвэрлэлийн чадамжийг бууруулж байгаа нь ханшийг өсгөхгүй байх гол хөшүүргүүдийн нэг болж байна.

Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.



ТӨМРИЙН ХҮДРИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2022 оны 01-р сарын 10

Долоо хоногийн онцлох үйл явдал

БНХАУ-ын цагаан сарын баярын өдрүүд болох гэж буйтай холбоотой баяр наадмын өдрүүдээр болон түүний дараагаар төмрийн хүдрийн эрэлт сэргэх байх гэсэн хүлээлттэй холбоотой төмрийн хүдрийн ханш өсөж байна.

Fastmarkets MB-ийн мэдээллээр 62 хувийн агууламжтай Northern China нөхцөлөөр худалдаалагдаж буй төмрийн хүдрийн ханш баасан гарагт өмнөх өдрөөс 0.3 хувиар өсөж 128.03 хүрснээр 10 сарын 12 өдрөөс хойшхи хамгийн өндөр үзүүлэлтэндээ хүрээд байна. Далианы таваарын биржийн төмрийн хүдрийн хамгийн идэвхитэй арилжаалагддаг 5 сарын гэрээний ханш баасан гарагт өмнөх өдрөөс 1.4 хувиар өсөж 719 юань /112.78 ам.доллар/ хүрлээ.

Sinosteel Futures-ийн шинжээчийн мэдэгдэж байгаагаар түүхий эд материалуудын үнийн өсөлт болон Өвлийн олимптой холбоотой бүтээгдэхүүний хязгаарлалт зэрэг нь гангийн ханшийг өсгөөд байгаа боловч эрэлт тал сул хэвээр байгааг анхааруулсан байна.

Published on Investing.com, 10/Jan/2022 - 3:59:12 GMT, Powered by TradingView.

Iron ore fines 62% Fe CFR Futures, China, DCE:DCIOK2, D



Мөн түүний хэлж байгаагаар Бээжин 2022 өвлийн олимпын үеэр цэвэр агаартай байлгахын тулд ган хайлуулах, металлургийн кокс коксжуулах үйлдвэрүүдийн үйлдвэрлэлийг хязгаарлалт эрчимжих төлөвтэй байгаа юм байна:

Zhongzhou Futures-ийн шинжээчдийн мэдэгдэж байгаагаар өвлийн олимпын дараагаар гангийн үйлдвэрлэлийн хязгаарлалт суларч үйлдвэрлэл идэвхижих төлөвтэй байна.

Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.



ЗЭСИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

Долоо хоногийн онцлох үйл явдал

2022 оны 1-р сарын 10

Covid 19 цар тахлын нөхцөл байдал болон Казакстаны бослого зэрэгтэй холбоотой зэсийн нийлүүлэлтийн саатал үүсч болзошгүй байна. Мөн энэ онд АНУ-ын ХНС бодлогын хүүг өсгөж бондын борлуулалтыг эхлүүлэх төлөвтэй байгаа нь доллар суурьтай таваарын бүтээгдэхүүнд хөрөнгө оруулахад тохиромжтой нөхцөл байдал үүсээд байна.

Өмнөх долоо хоногийн баасан гарагт Нью-Йоркийн Comex таваарын биржид арилжаалагддаг зэсийн гурван сарын гэрээний ханш өмнөх өдрөөс 0.9 хувиар өсөж паунд нь 4.39 ам.доллар дээр хаагдлаа. Харин БНХАУ-ын Шанхайн таваарын биржид хамгийн идэвхитэй арилжаалагддаг зэсийн 2 сарын гэрээний ханш 0.5 хувиар унаж 69,560 юань хүрсэн байна.

Published on Investing.com, 10/Jan/2022 - 4:26:41 GMT, Powered by TradingView.

Copper Futures, (CFD):HG, D



Goldman Sachs Group-ийн таваарын судалгаа хариуцсан захирал Jeff Currie-ийн мэдэгдэж байгаагаар ирэх онуудад таваарын бүтээгдэхүүний супер циклүүд үргэлжлэх төлөвтэй байгаа бөгөөд таваарын бүтээгдэхүүний зах зээлийг өндөр өсөлттэй байх боломжтой хэмээн бодож байгаагаа мэдэгдсэн байна.

Мөн түүний хэлж байгаагаар АНУ-ын Холбооны нөөцийн сангийн авч хэргэжүүлэх гэж байгаа бодлогуудтай холбоотой таваарын бүтээгдэхүүнд хөрөнгө оруулалт хийх нь маш тохиромжтой байгаа юм байна.

Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.



Холбоо барих



Т.Азтүшиг
Ахлах шинжээч

aztushig@golomtcapital.com
9997-0303

Golomt Capital®

